



“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 26 өдөр

Дугаар ХЗ-21/01

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.11.9 дэх заалт, “Монгол шуудан” хувьцаат компанийн 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол шуудан” хувьцаат компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх “Сайн” гэж дүгнэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ





“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 26 өдөр

Дугаар ХТ-21/02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны
зардлын төсөв батлах тухай


Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “Монгол шуудан” хувьцаат компанийн 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол шуудан” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг хавсралтын дагуу нийт 155,600,000.00 (Нэг зуун тавин таван сая зургаан зуун мянган) төгрөгөөр баталсугай.
2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх цалин урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ



“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
 ээлжит хурлын 2021 оны 04 сарын 26 өдрийн
 ХЭ-21/02 дугаар тогтоолын хавсралт



“Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
 2021 оны зардлын төсөв

№	Зардлын төрөл	Тоо	Нэгж зардал /мян.төг/	Сар	Нийт /мян.төг/
1. Цалингийн зардал					
1	ТУЗ-ийн дарга	1	1,200.0	12	14,400.0
2	Хорооны дарга	3	1,100.0	12	39,600.0
3	Гишүүд	5	1,000.0	12	60,000.0
4	Н/б-ийн дарга	1	900.0	12	10,800.0
5	ЭМ/НДШ /13.5%/			12	16,800.0
Дүн					141,600.0
2. Бичиг хэрэг, хангамж болон бусад зардал					
7	Бичиг хэрэг, хангамжийн зардал	1	125.0	12	1,500.0
8	Шатахууны зардал				2,500.0
9	Томилолтын зардал				10,000.0
Дүн					14,000.0
НИЙТ ЗАРДАЛ					155,600.0



“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 26 өдөр

Дугаар ХЗ-21/03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, “Монгол шуудан” хувьцаат компанийн 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.

2. “Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнээр дор дурдсан нэр дэвшигчдийг 2 жилийн хугацаатайгаар сонгосугай.

2.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:

- 2.1.1 Монгол Улсын иргэн Даваахүү Нарангэрэл
- 2.1.2 Монгол Улсын иргэн Даваасамба Дэлгэрмаа
- 2.1.3 Монгол Улсын иргэн Энхбаатар Бат-Идэр
- 2.1.4 Монгол Улсын иргэн Чулуунбаатар Дондогмаа
- 2.1.5 Монгол Улсын иргэн Одончимэд Одбаяр
- 2.1.6 Монгол Улсын иргэн Гэрэлт Тэлмэн

2.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:

- 2.2.1 Монгол Улсын иргэн Дарамбазар Балдорж
- 2.2.2 Монгол Улсын иргэн Банзрагч Ганбаатар
- 2.2.3 Монгол Улсын иргэн Ванчиг Ганзориг

ХУРЛЫН ДАРГА *Д. Нарангэрэл* Д.НАРАНГЭРЭЛ

